

ЭРХҮҮГИЙН МОНГОЛЧ
А. В. ИГУМНОВ (1761—1834 ОН)

Ю. В. Кузьмин (Эрхүү)

1991 онд Эрхүүгийн нэрт монголч Александр Васильевич Игумновын мэндэлсний 230 жилийн ой болж байна. Тэрээр Оросын түүхэнд анх удаа 4 ботьтой монгол-орос толь бичгийг зохиож, Эрхүү, Дээд Үд, Хиагт зэрэг Дорнод Сибирьт монгол хэлний орчуулагч, багшийн ажил хийж байжээ.

XIX зууны 20-иод онд Европт монгол хэлний тэнхимтэй их сургууль нэг ч үгүй байлаа. Тэр үеийн Орост Я. И. Шмидт (1779-1847) монгол хэлээр, нанхиадач Н. Я. Бичурин (1777—1853) монголын түүхээр судалгаа хийж байлаа.

1827 оноос эхлэн Казанийн Их Сургуульд монгол хэлний тэнхим нээх тухай асуудал яригдах болов. Үүний тулд Эрхүүд амьдарч байсан А. В. Игумновт шавь оруулахаар О. М. Ковалевский, А. В. Попов нарын хоёр оюутныг илгээхээр шийдвэрлэжээ. А. В. Игумнов тэднийг сургахыг зөвшөөрч Сибирийн сургуулийн байцаагч П. А. Словцовт: «..Амьдралын минь өдрүүд барагдаж байгаа энэ үед энэхүү хоёр оюутныг дуртай нь аргагүй монгол хэлэнд сургаж, өөрийн өнөөг хүртэл сурч мэдсэн зүйлээ бүгдийг тэдэнд өвлүүлэн үлдээхээр чармайх болно» гэж бичиж байв.

Игумнов авгай Хятадтай хил залгадаг Кударин цайзын орчим нутагт 1761 онд төржээ. Түүний эцэг монгол, манж хэлний хэлмэрч байсан учир хүүдээ хэрэг болох вий хэмээн заан сургасан байна. Игумновын бага нас буриад нарын дунд өнгөрсөн тул монголоор шаггүй ярьж сурчээ. 1771 онд эцэг нь Игумновыг Селенгинскэд дөнгөж байгуулагдаад байсан монгол хэлний сургуульд оруулсан бөгөөд тэр сургуулийг 1777 онд дүүргэжээ.

Дараа нь тэрээр Хиагтын хилийн албанд хэлмэрчээр ажиллаж байгаад 1781—1782 онд Хятад явсан оросын шашны элч төлөөлөгчдийг дагалдан хэлмэрчилж ихэд үнэлэгдэж байв.

Эрхүүгийн ерөнхий захирагч Ф. Н. Кличкигийн дэмжлэгээр хэсэг хугацаанд Москва болон Петербургт сууж Монгол, монголын соёлын тухай ном зохиолтой танилцаж нийслэлийн судлаачидтай санал солилцож байлаа. Тэнд байхдаа Игумнов монгол-орос толь бичиг зохиол шаардлагатайг ухаарчээ.

1813 онд А. В. Игумнов хувийн орос-монгол сургуулийг нээж, мөн 1822 оноос Эрхүүгийн шашны семинарт монгол хэл зааж ирсэн байна.

А. В. Игумнов олон жилийн туршид монгол-орос толь зохиох ажлыг шаргуу хийж 4 боть дүүргэсэн байна. Дараагаар нь цагаан толгойн дарааллаар толь бичиг зохиож эхэлсэн боловч дуусгаж амжилгүй зөвхөн эхний ботийг үлдээсэн билээ.

Нийгэм-улс төрийн үзэл бодлоороо соён гийгүүлэгч болох Игумнов Сибирийн цөллөгт байсан декабристуудтай ойр дотно байж, Сибирийн нийгмийн дэвшилтэт хэсэгт хамрагдаж байлаа. Өөрийн үзэл бодлоос болж байн байн хяхан хавчигдаж, цагдаагийн хяналтанд орж Эрхүүгээс хэд хэдэн удаа явж ажил төрөл, амьдрах орчноо өөрчлөхөд хүрч байв.

Орос оронд монгол зэрэг дорнодахины хэлийг судлах, угсаатны зүйн материал, гар бичмэл цуглуулж шинжлэх ажил XVIII зууны эхээр эхэлсэн бөгөөд энэ нь нэгдүгээр Петр хаантай шууд буюу дам холбоо-

той. Түүний идэвхтэй гадаад бодлого, Урал болон Сибирийг эзэмших үйл ажиллагаа дорнодахины хөрш орнуудын талаар мэдлэгийг практик ач холбогдолтой болгов. Эхэн үедээ эрдэм шинжилгээний бус харин Монгол, Хятадтай дипломат, худалдааны харьцааг хөгжүүлэх практик шаардлага монгол хэл, түүний түүх соёлыг судлах үндсийг тавьж өгчээ.

XVII зууны сүүлчээс Эрхүүгийн худалдаачид Монголтой хийх тэмээн жингийн худалдаанд идэвхтэй оролцох болж 1727-1728 онд Орос Хятадын хооронд Буурын болон Хиэгтын гэрээг байгуулсны дараачаар хоёр талын худалдаа байнга, эрчимтэй явагдах болов. 1792 он хүртэл гаалийн алба Эрхүүд байсан бөгөөд сүүлд Хиэгтад шилжсэн юм. Дипломат, худалдааны хэлхээ холбоо өргөжихийн сацуу монгол хэл мэддэг чадвартай хүмүүс шаардагдав. Эрхүүд ийм хүмүүсийн тоонд В. А. Игумнов, А. А. Бобровников нар орж байлаа.

Нэрт дорнодахинч В, В, Бартольд «Европ болон Орост Дорнодахиныг судалсан түүх» номондоо: «Их сургуульд монгол хэлийг заах тухай шийдвэр гарснаар тухайн үедээ монгол хэлэнд гаргуун байсан Игумнов монгол хэл судлалын ирээдүйн профессоруудын багш болов» гэж бичсэн байна.

Игумнов авгай О. А. Ковалевский А. В. Попов нарыг Эрхүүд халуун дотноор угтжээ. Игумнов гол төлөв монгол гар бичмэлээс бүрдсэн өөрийн баялаг номын сантай байлаа. Тэрээр өөрийн зохиосон сурах бичиг, гарын авлагаар шавь нараа сургаж байжээ. Үүнд 3 дэвтэртэй «Монголоор зөв бичих дүрмийг» онцгойлон дурьдах хэрэгтэй.

Вильнюсын Их сургуулийн гар бичмэл санд хадгалагдаж буй О. М. Ковалевскийн материал дотор Игумновын зохиож Ковалевскийн гараар хуулж бичиж авсан «Монгол цагаан толгой» олдсон байна. Ер нь Ковалевскийн өнөө ч ач холбогдлоо алдаагүй «Монгол-орос-франц толь бичгийг» (1844—1849 он) зохиох явцад Игумновын толь бичиг нэлээдгүй үүрэг гүйцэтгэснийг тэмдэглэвэл зохино.

1833 онд О. М. Ковалевский Казаньд эргэн ирж тус их сургуульд Орост анхны монгол хэлний тэнхимийг нээж Монгол хэл, түүх соёлоор хичээл зааж, эрдэм шинжилгээний бүтээлээ туурвих болжээ.

1855 онд Петербургийн Их Сургуульд монгол, халимаг хэлний тэнхим нээгдэж цаашдаа монгол судлалын төв болон өргөжин хөгжив. Оросын монгол судлалын хойшдын хөгжил Г. Гомбоев, К. Ф. Голстунский, А. М. Позднеев, Б. Я. Владимирцов, В. Л. Котвич, В. В. Бартольд нарын нэртэй салшгүй холбоотой.

Оросын шинжлэх ухааны энэхүү салбарын хөгжил бадрал нь Эрхүүд багшилж байсан А. В. Игумнов нарын өнөөдөр бараг мартагдсан даруухан боловч ажилч хичээнгүй хүмүүсийн тавьсан үндэс суурин дээр тулгуурласныг маргахын аргагүй.